ХОВД АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2019 оны 06 сарын 17 өдөр Дугаар 9/01 Ховд

Хэлэлцэх асуудал, дотоод журам,
үйлчлэх Ажлын албадыг батлах тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 9 дүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 9 дүгээр хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн 85 хувийн саналаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 9 дүгээр хуралдаанаар хэлэлцэх асуудлыг 1 дүгээр хавсралтаар, дотоод журмыг 2 дугаар хавсралтаар, хуралдаанд үйлчлэх Ажлын албадыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

ХУРЛЫН ДАРГА Г.ПҮРЭВГАНДИ

Аймгийн ИТХ-ын 9 дүгээр хуралдааны
9/01. дүгээр тогтоолын 1 дүгээр
хавсралт

АЙМГИЙН ИТХ-ЫН 9 ДҮГЭЭР ХУРАЛДААНЫ ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

1.а "Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 2016-2020 оны хөтөлбөрийн болон аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн явцын тухай" мэдээлэл

б. "Бүсчилсэн хөгжлийг дэмжих саналын тухай" мэдээлэл

Илтгэгч нь: Аймгийн Засаг дарга Б.Дүгэржав

2. "Аймгийн 2019 оны төсөвт тодотгол хийх тухай" илтгэл

Илтгэгч нь: Аймгийн Засаг дарга Б.Дүгэржав

3. "Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн тухай" мэдээлэл

Илтгэгч нь: Аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар

4. "Аймгийн газар зохион байгуулалтын 2019 оны төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" илтгэл

Илтгэгч нь: Аймгийн Газрын харилцаа, барилга,
хот байгуулалтын газрын дарга Б.Баярсүх

5. "Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах санал уламжлах тухай" илтгэл

Илтгэгч нь: Аймгийн Байгаль орчин, аялал
жуулчлалын газрын дарга Л.Батбаяр

6. "Ховд аймгийн нутаг дэвсгэрт шашны байгууллага, сүм хийд байгуулах, зөвшөөрлийн хугацаа сунгах, хяналт тавих журам"-ын тухай илтгэл

Илтгэгч нь: Аймгийн ИТХ-ын төлөөлөгч, журам
боловсруулах ажлын хэсгийн ахлагч Ш.Батсүх

---oOo---

Аймгийн ИТХ-ын 9 дүгээр хуралдааны
9/01 дүгээр тогтоолын 2 дугаар
хавсралт

ДОТООД ЖУРАМ

1.а "Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 2016-2020 оны хөтөлбөрийн болон аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн явцын тухай" мэдээлэл

/20 минут/

б. "Бүсчилсэн хөгжлийг дэмжих саналын тухай" мэдээлэл

/10 минут/

2. "Аймгийн 2019 оны төсөвт тодотгол хийх тухай" илтгэл

/20 минут

3. "Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн тухай" мэдээлэл

/10 минут/

4. "Аймгийн газар зохион байгуулалтын 2019 оны төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" илтгэл

/20 минут/

5. "Зарим газар нутгийн улсын тусгай хамгаалалтад авах санал уламжлах тухай" илтгэл

/ 10 минут/

6. "Ховд аймгийн нутаг дэвсгэрт шашны байгууллага, сүм хийд байгуулах, зөвшөөрлийн хугацаа сунгах, хяналт тавих журам"-ын тухай илтгэл

/ 10 минут/

7. Аймгийн ИТХ-ын төлөөлөгчид, урилгаар оролцогчид үг хэлнэ.

/Хэлэлцэх асуудал тус бүрт хүн бүр эхний удаа 5 минут,
дараагийн удаа 3 минут/

8. Хуралдаанаас гарах шийдвэр батлах

/Цаг тогтоохгүй/

9. Хуралдааныг 2 цаг тутамд 10 минутын завсарлагатайгаар товлосон өдөрт багтаан дуусгана.

---oOo---

Аймгийн ИТХ-ын 9 дүгээр хуралдааны
9/01 дүгээр тогтоолын 3 дугаар
хавсралт

АЙМГИЙН ИТХ-ЫН 9 ДУГААР ХУРАЛДААНД ҮЙЛЧЛЭХ АЖЛЫН АЛБА

А. Нарийн бичгийн даргаар:

А.Түмэндэлгэр - Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн Ажлын албаны НУБЗХ-ийн мэргэжилтэн

Г.Бадамсүрэн - Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн Ажлын албаны ОНИХХ-ийн мэргэжилтэн

Б.Гантөмөр – Аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-ийн ахлах мэргэжилтэн

Б. Редакцийн комиссоор:

М.Отгонхишиг- Аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-ийн мэргэжилтэн

С.Дорж - Аймгийн ЗДТГ-ын НБХ-ийн мэргэжилтэн

В. Тэмдэглэл хөтлөгчөөр:

Р.Цэцэгжаргал –Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн Ажлын албаны НУБЗХ-ийн мэргэжилтэн

С.Батцэцэг -Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн Ажлын албаны НУБЗХ-ийн мэргэжилтэн

Г. Хэлэлцэх асуудалтай холбогдуулан гарах тогтоолын төсөл боловсруулах ажлын хэсэг:

Ахлагч Ш.Батсүх- Аймгийн ИТХ-ын төлөөлөгч

Гишүүд: Д.Баасандорж- Аймгийн ИТХ-ын төлөөлөгч

Ц.Бат-эрдэнэ- Аймгийн ИТХ-ын төлөөлөгч

Д.Нямлхагва-Аймгийн ИТХ-ын төлөөлөгч

Х.Болдбаатар- Аймаг дахь Төрийн аудитын газрын

дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар

Ч.Багдал- Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга

Б.Баярсүх- Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга

---oOo---

ХОВД АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2019 оны 06 сарын 17 өдөр Дугаар 9/02 Ховд

Аймгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийн
төсөл,хөтөлбөрийн жагсаалт батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “е”, 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, аймгийн Засаг даргын саналыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 9 дүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Аймгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийн төсөл, хөтөлбөрүүдийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.Тэргүүлэх чиглэлийн төсөл хөтөлбөрүүдийг Монгол улсын Үндэсний болон аймгийн хөгжлийн дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд тусгуулж, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /Б.Дүгэржав/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА Г.ПҮРЭВГАНДИ

9 дүгээр хуралдааны 9/02 дугаар
тогтоолын хавсралт

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮДИЙН ЖАГСААЛТ

№	Төслийн нэр	Суурилагдах хүчин чадал	Төсөвт өртөг /тэрбум/
1	Эрдэнэбүрэнгийн Усан цахилгаан станц	64 мВт-ыг 96-100 мВт болгох	780,0
2	Ховд Эко цементийн үйлдвэр	Жилд 500 000 тонн цемент	150,0
3	Малын гаралтай түүхий эд боловсруулах төв цэвэрлэх байгууламж	Өдөрт 1500 м3	5,0
4	Газрын тос боловсруулах бага хүчин чадлын үйлдвэр	Нефть боловсруулалт нь жилд 50,000тн	8,0
5	Хашаандаа сайхан амьдарцгаая	3000 гаруй айл өрхөд	25,0
6	“Ховд агропарк” хөдөө аж ахуйн цогц төсөл	1600 га талбай	15,0
7	Ховд Олон улсын Нисэх буудлыг өргөтгөх	Зорчигч 25000 Ачаа 400000 кг	10,0
8	“Дулааны станцын хүчин чадлыг нэмэгдүүлэх, өргөтгөх”	36 Гкал/ц хүчин чадалтай дулааны станцыг 21 Гкал/ц-аар өргөтгөх	5,55
9	“Гурван сэнхэр төвтэй таван од” аялал жуулчлалын цогцолбор	Нэг ээлжиндээ 200 жуулчин	5,0
10	Баруун Монголын соёл угсаатны зүй музей, театр урлагийн цогцолбор	3000 хүнд нэг удаа үйлчлэх	21,0
11	Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн эмнэлгийн барилгын өргөтгөл	200 ор	5,5
12	Цэвэр, бохир усны төв шугам сүлжээ шинэчлэх	Цэвэр ус-1км Бохир ус-2,6км	1,5
13	Дулааны шугам сүлжээ шинээр барих, өргөтгөх	ДДТөв-2ш, Дулааны шугам сүлжээ	2,35
14	Орчин үеийн тоног төхөөрөмж бүхий улаан боржин чулууны үйлдвэрийн цогцолбор	-	-
15	БНХАУ, ОХУ-тай хамтарсан мод боловсруулах үйлдвэр /тоглоомын үйлдвэр /	-	-
16	Баруун бүсийн лаборатори, эрдэм шинжилгээ, судалгааны төв байгуулах	Нэг аймагт Өдөр 10-15 мянган малыг шинжилгээнд хамруулах. Баруун 5 аймгийн малын гаралтай түүхий эд,	11,2

		бүтээгдэхүүнд шинжилгээ хийх.	
17	Англи, Орос, Хятад хэлний гүнзгийрүүлсэн сургалттай бүсийн ерөнхий боловсролын сургуулийн цогцолбор	640 хүүхэд	5,0
18	Ховд гол дагуух сумдад услалтын систем байгуулах	10 мянган га	20,0
19	Баруун бүсийн перинатологийн төв байгуулах / Эх нярайн төв /	Жилд дунджаар бүсийн 180000 эх нярайд хүрч үйлчлэх тусламж үйлчилгээ, сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны төв	1.0
20	Нар, салхины эрчим хүчний станц	10 мВт	75.0
21	Барилгын материалын үйлдвэр, бүсийн нэгдсэн лаборатори	Баруун бүсийн барилгын материалын бүх төрлийн дээж, сорьц авах	1.0
22	Сангийн хэрмийг засаж тохижуулах / Зураг макет, археологийн судалгаа хийлгэсэн /	320 хүний ажлын байр бий болгох	1.5
23	Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах	Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 10-15 жилийн төлөвлөгөөтэй болох	1.0
24	Бугат үзүүр орчимд усан сан байгуулах / Хиймэл нуур/	3 сая метр куб	2.3
25	Баруун бүсийн Зооноз өвчин судлалын төв	Жилд дунджаар 80000 хүнд хүрч үйлчлэх сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны бааз байгуулах	1.8
26	Чоно харайхын гүүр, Ээвийн гүүр	70 метр урттай төмөр бетонон гүүр	3.0
27	Ховд хотын үерийн ус зайлуулах суваг, далан байгуулах	22 км далан сувагчлал байгуулах	3.0
28	Ховд хотыг Завхан аймгийн Улиастай хоттой Сар хайрхны чиглэлээр, Увс аймгийн Улаангом хоттой Наранбулаг чиглэлээр хатуу хучилттай авто замаар холбох	Ховд- Сар хайрхан чиглэл-100 км Ховд-Наранбулагт чиглэл -160 км, Нийт 260 км хатуу хучилттай зам	182.0 /3 дугаар ангиллын 1 км зам байгуулахад 700.0 сая д дундаж тооцоолол/
29	Буянт, Үенч, Гурван сэнхэр, Булган голд ус нөөцлөх, загас үржүүлэх / хөв цөөрөм/	1.5 сая метр куб	Нэгжид 1.5
30	Аялал жуулчлалын бүсүүдийг цахилгаан дамжуулах агаарын шугамд холбох	-	10.0

ХОВД АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 06 сарын 17 өдөр Дугаар 9/03 Ховд

Аймгийн 2019 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулж батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ийн "б", 19 дүгээр зүйлийн 19.1 дэх заалтыг үндэслэн аймгийн Засаг дарга Б.Дүгэржавын "Аймгийн 2019 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулж батлах тухай" илтгэлийг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 9 дүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын нийт дүн, орлогын нэр төрлийн хэмжээг дор дурдсанаар баталсугай.

/мянган төгрөгөөр/

I	Төсвийн нийт орлого	8507640.0
II	Суурь орлого	8500790.0
1.	Урсгал орлого	8398990.0
1.1	Татварын орлого	7219550.0
1.1.1	Хувь хүний орлогын албан татварын тухай[1] хуулийн 8.1.1-д заасан орлогод ногдох албан татвар	5852000.0
1.1.1.1	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	6712000.0
1.1.1.2	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-860000.0
1.1.2	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	332500.0
1.1.3	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	455000.0
1.1.4	Төсвийн тухай хуулийн 23.4.9-д зааснаас бусад улсын тэмдэгтийн хураамж	221500.0
1.1.5	Газрын төлбөр	215000.0
1.1.6	Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр	120250.0
1.1.7	Бусад татвар, төлбөр хураамж	23300.0
1.2	Татварын бус орлого	1359440.0

1.2.1	Ногдол ашиг	10000.0
1.2.2	Хүү, торгуулийн орлого	684940.0
1.2.3	Төсөвт байгууллагын өөрийн орлого	138500.0
1.2.4	Төсөвт төвлөрүүлэх бусад орлого	346000.0
2	Хөрөнгийн орлого	101800.0
3	Нийт орлогод орох бусад орлого	6850.0
3.1	ТЗШ-гээр санхүүжих төсвийн байгууллагын өөрийн орлого	6850.0

Хоёр. Аймгийн төсөвт төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллага, бусад байгууллагын төвлөрүүлэх орлогын хэмжээг дор дурдсанаар баталсугай.

/мянган төгрөгөөр/

2.1	Засаг дарга	138,500.0
1	Аймгийн ЗДТГ	72,000.0
2	Орон нутгийн өмчийн газар	12,150.0
3	Асрамжийн газар	1,000.0
4	Ойн анги	4,000.0
5	Байгаль орчин, аялал жуулчлалын газар	1,000.0
8	Орон нутгийг судлах Музей	6,000.0
9	Номын сан	2,500.0
10	ХДТ	30,000.0
11	Биеийн тамир спортын газар	10,000.0
12	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	6,850.0

Гурав. Аймгийн төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч нарт дор дурдсан төсөв зарцуулах эрхийг олгосугай.

/мянган төгрөгөөр/

д/д	Төсвийн захирагч	Дүн
1.	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга	504833.8
	Урсгал зардал:	504833.8
	Хөрөнгийн зардал:	0.0
	Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга	504833.8
	Үндсэн үйл ажиллагаа	331428.8
	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	129000.0
	Мэдээлэл сурталчилгааны зардал	2400.0
	Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлс	5000.0
	Биеийн тамирын арга хэмжээ	405.0
	ИТХ-д суудалтай намд олгох дэмжлэг	18600.0
	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	6000.0
	Орон нутгийн сонгууль зохион байгуулах	12000.0
2.	Засаг дарга	
	Урсгал зардал:	8139740.0
	Хөрөнгийн зардал:	6072740.0

		2067000.0
	Аймгийн Засаг даргын тамгын газар Урсгал зардал Үндсэн үйл ажиллагаа Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ Мэдээлэл сурталчилгааны зардал Харуул хамгаалалтын зардал Биеийн тамирын арга хэмжээ Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг Нөөц хөрөнгө Баяр наадам зохион байгуулах Цэргийн дүйцүүлэх алба	18456 46.8 1147925.3 230000.0 10800.0 18000.0 2000.0 7000.0 364921.5 10000.0 55000.0
	Санхүүгийн хяналт, аудитын алба Үндсэн үйл ажиллагаа Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	128631.7 126631.7 2000.0
	Орон нутгийн өмчийн газар Үндсэн үйл ажиллагаа Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	190697.3 188697.3 2000.0
	Байгаль орчин аялал жуулчлалын газар Үндсэн үйл ажиллагаа Мэдээлэл сурталчилгааны зардал Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	413394.3 401694.1 430.0 11270.2
	Ойн анги Үндсэн үйл ажиллагаа Харуул хамгаалалтын зардал Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	 50820.0 44720.0 5500.0 600.0
	Халамжийн сан Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламж Өр барагдуулах	241380.9 34880.9 120000.0 86500.0
	Аймгийн асрамжийн газар Үндсэн үйл ажиллагаа Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ	248864.5 237344.5 11520.0
	Засаг дарга шууд Ахмад настны хөгжил хамгаалал Жолоочийн ХДС-д олгох шилжүүлэг Хотын нийтийн хүн тээврийн татаас Авто тээврийн хяналтын постын зардал Гэр хорооллын усны үнийн хөнгөлөлт	1107921.9 62798.6 42500.0 45000.0 30000.0

	Байгаль хамгаалах сан МЭУСАХ-ий зардал Хөрөнгө оруулалтын хяналтын зардал Германы хамтын ажиллагааны төслийн үйл ажиллагааны зардал	55320.0 620488.0 22215.3 199600.0 30000.0
	Номын сан Үндсэн үйл ажиллагаа Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	218623.6 218123.6 500.0
	Музей Үндсэн үйл ажиллагаа Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	170515.8 170015.8 500.0
	Хөгжим дармын театр Үндсэн үйл ажиллагаа Уран бүтээл хийх Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	793745.7 723832.5 43386.8 26526.4
	Биеийн тамир спортын газар Үндсэн үйл ажиллагаа Биеийн тамирын уралдаан тэмцээн Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	486496.6 442597.1 34500.0 9399.5
	Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн хэлтэс /тогтмол зардал/	137829.1
	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар /тогтмол зардал/	38171.8
	Хөрөнгийн зардал Замын сангийн засвар, арчилгаа ОН-ийн хөрөнгө оруулалт	2067000.0 450900.0 1616100.0

Дөрөв. Аймгийн 2019 оны төсвийн жилд зарцуулах төсвийн зарлагын хэмжээг 8644573.8 мянган төгрөгөөр баталсугай.

Тав. Аймгийн замын сангийн их засварын зардлын хэмжээг 450900.0 мянган төгрөгөөр баталсугай.

Зургаа. Аймгийн төсвөөс сумын төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг дор дурдсанаар баталсугай.

/мянган төгрөгөөр/

Д/д	Сумын нэр	Дүн
6.1.	Алтай	482377.8
6.2.	Булган	591593.1
6.3.	Буянт	410861.5
6.4	Дарви	409353.9

6.5	Дөргөн	437375.9
6.6	Дуут	435190.4
6.7	Зэрэг	527061.6
6.8	Манхан	734261.0
6.9	Мянгад	509607.5
6.10	Мөст	347917.4
6.11	Мөнххайрхан	368220.5
6.12	Үенч	413379.7
6.13	Ховд	395430.6
6.14	Цэцэг	457712.9
6.15	Чандмань	481564.3
6.16	Эрдэнэбүрэн	566564.3
6.17	Жаргалант	2241248.5
	Нийт дүн	9809721.03

Долоо. Сумын төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг дор дурдсанаар баталсугай.

/мянган төгрөгөөр/

Д/д	Сумын нэр	Дүн
7.1	Алтай	101700.0
7.2	Булган	475000.0
7.3	Буянт	107500.0
7.4	Дарви	112300.0
7.5	Дөргөн	185200.0
7.6	Дуут	77800.0
7.7	Зэрэг	114500.0
7.8	Манхан	130600.0
7.9	Мянгад	99800.0
7.10	Мөст	102300.0
7.11	Мөнххайрхан	101050.0
7.12	Үенч	315500.0
7.13	Ховд	94800.0
7.14	Цэцэг	145100.0
7.15	Чандмань	98700.0
7.16	Эрдэнэбүрэн	93500.0
7.17	Жаргалант	897100.0
	Нийт дүн	3252450.0

Найм. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас сумын орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн хэмжээг дор дурдсанаар баталсугай.

/мянган төгрөгөөр/

Д/д	Сумын нэр	Дүн	Үүнээс: Урсгал зардал
8.1	Алтай	284884.2	16211.8
8.2	Булган	466015.5	20769.0

8.3	Буянт	119116.8	28367.6
8.4	Дарви	193806.9	29773.1
8.5	Дөргөн	125914.8	27517.9
8.6	Дуут	105553.3	16237.8
8.7	Зэрэг	134194.8	28677.1
8.8	Манхан	164059.8	33848.9
8.9	Мянгад	201960.5	25240.3
8.10	Мөст	131056.7	29440.2
8.11	Мөнххайрхан	103883.5	20438.2
8.12	Үенч	257365.7	18754.4
8.13	Ховд	95011.4	30166.4
8.14	Цэцэг	135718.4	28573.6
8.15	Чандмань	132047.3	26364.7
8.16	Эрдэнэбүрэн	88427.5	30157.9
8.17	Жаргалант	408037.8	119366.5
	Нийт дүн	**3147054.9**	**529905.4**

Ес. Тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих зардлыг дор дурдсанаар өөрчлөн баталсугай.

/мянган төгрөгөөр/

д/д	Сумдын нэрс	ЕБС	СӨБ	Эрүүл мэндийн төв		бусад үйлчилгээ	Нийт зардлын дүн
				ТЗШ	ЭМДС		
1	Алтай	795923.8	243571.1	373276.0	32549.8	0.0	**1445320.7**
2	Булган	2859386.4	986952.5	0.0	0.0		**3846338.9**
3	Буянт	753112.0	276386.5	336522.0	36847.3		**1402867.7**
4	Дарви	847765.3	234323.1	353618.4	30466.7		**1466173.5**
5	Дөргөн	858566.1	362771.2	329176.4	21558.3		**1572072.0**
6	Дуут	523361.5	187063.7	315474.8	20810.0		**1046710.0**
7	Зэрэг	897888.3	367466.6	350184.7	32812.7		**1648352.3**
8	Манхан	1010534.1	298002.3	345655.2	42641.3	0.0	**1696832.9**
9	Мянгад	739238.6	241543.1	352699.6	36705.7		**1370186.9**
10	Мөст	948013.0	280668.1	0.0	0.0		**1228681.1**
11	Мөнххайрхан	663291.8	238009.5	339820.8	22407.7		**1263529.8**
12	Үенч	1031894.9	373385.8	375026.0	41367.2		**1821673.9**
13	Ховд	910373.4	275273.4	343344.8	35937.2		**1564928.8**
14	Цэцэг	713492.7	370498.5	322125.6	30850.9		**1436967.7**
15	Чандмань	783014.6	279935.6	349846.4	29698.2		**1442494.8**
16	Эрдэнэбүрэн	613717.2	178381.7	309068.2	24005.3		**1125172.4**
17	Жаргалант	8778070.6	5115035.6	0.0	0.0		**13893106.2**
	Нийт дүн	**23727644.0**	**10309268.4**	**4795838.9**	**438658.3**	**0.0**	**39271409.6**
1	Өрхийн эрүүл мэндийн төв			621900.8			**621900.8**
2	ХГБХХ					293058.8	**293058.8**
3	ГХБХБГазар	0				401205.4	**401205.4**
	Төвийн дүн	**0**	**0**	**621900.8**		**694264.2**	**1316165.0**
	НИЙТ ДҮН	**23727644.0**	**10309268.4**	**5417739.7**	**438658.3**	**694264.2**	**40587574.6**

Арав. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмж, их засварын зардлын дээд хэмжээг 1616100.0 мянган төгрөгөөр өөрчлөн баталсугай.

Арван нэг. Аймгийн төсвөөс орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд төвлөрүүлэх орлогын хэмжээг 346328.9 мянган төгрөгөөр баталсугай.

Арван хоёр. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмж, их засварын зардлын дээд хэмжээг 3896870.9 мянган төгрөгөөр өөрчлөн баталсугай.

Арван гурав. Хөшөөт хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, их засварын зардлын дээд хэмжээг 1543801.7 мянган төгрөгөөр өөрчлөн баталсугай.

Арван дөрөв. Сумдын 2018 оны давсан орлогоос 180.0 сая төгрөгийг аймгийн төсвийн эх үүсвэрт татан төвлөрүүлсүгэй.

Арван тав. Аймгийн 2019 оны төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийг дор дурдсанаар өөрчлөн баталсугай.

1.Төсвийн нийт орлого 8507640.0 мянган төгрөг

2.Аймгийн төсөвт улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 8989028.6 мянган төгрөг

3.Аймгийн төсөвт улсын төсвөөс шилжүүлэх тусгай зориулалтын шилжүүлэг 40148916.3 мянган төгрөг

4.Аймгийн төсөвт эрүүл мэндийн даатгалын сангаас олгох санхүүгийн дэмжлэг 438658.3 мянган төгрөг

5.Аймгийн ОНХС-д улсын төсвөөс олгох орлогын шилжүүлэг 6667910.7 мянган төгрөг

6.Хөшөөт хөгжил сангийн санхүүжилт 1152000.0 мянган төгрөг, урьд оны үлдэгдэл 189000.0 мянган төгрөг, авлага барагдуулалтаас 125000.0 мянган төгрөг, Хөшөөт багийн нүүлгэн шилжүүлэлтийн зардал 77801.7 мянган төгрөг нийт 1543801.7 мянган төгрөг

7.Урьд оны үлдэгдлээс 300000.0 мянган төгрөг

8.Урьд оны давсан орлогоос 236506.8 мянган төгрөг, сумдын 2018 оны давсан орлогоос төвлөрүүлсэн 180000.0 мянган төгрөг нийт 416506.8 мянган төгрөгөөс /ОНХСанд 158178.9 мянган төгрөгийг, замын санд 68400.0 мянган төгрөгийг, ОН-ийн хөрөнгө оруулалтад 189928.3 мянган төгрөгийг/, урьд оны ОНХО-ын үлдэгдэл 142382.9 мянган төгрөг, ОНХС-ын үлдэгдэл 86921.5 мянган төгрөг, авлага барагдуулалтаас 194535.0 мянган төгрөг нийт 840346.2 мянган төгрөг

9.Хөрөнгө оруулалтын хяналтын зардал 199600.0 мянган төгрөг

Арван зургаа. Төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнг 1 дүгээр хавсралтаар, Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмжийн жагсаалтыг 2 дугаар хавсралтаар, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний жагсаалтыг 3 дугаар хавсралтаар, Замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээний жагсаалтыг 4 дүгээр хавсралтаар, Хөшөөт хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, их засварын жагсаалтыг 5 дугаар хавсралтаар, Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр хийгдэх хөтөлбөр, арга хэмжээний жагсаалтыг 6 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

Арван долоо. Аймаг, сумын төсвийн орлогын төлөвлөгөөг нэр төрөл, дүнгээр сар бүр биелүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг тогтмол хэрэгжүүлж, зарлагын санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэн, батлагдсан төсвийг хөтөлбөр, арга хэмжээнд зориулан хэмнэлтийн горимыг баримтлан үр ашигтай зарцуулж, төсөв санхүүгийн сахилга, хариуцлагыг сайжруулан, Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2 дахь заалтын дагуу төсөвт зохицуулалт хийж, өр төлбөр үүсгэхгүй, хуралдаанаар хэлэлцэх явцад гарсан санал шүүмжлэл, Хурлын дэргэдэх хороодоос оруулсан санал дүгнэлтийг үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагч /Б.Дүгэржав/, төсвийн бүх шатны захирагч нарт үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА Г.ПҮРЭВГАНДИ

ХОВД АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 06 сарын 17 өдөр Дугаар 9/04 Ховд

Санхүүгийн талаар авах арга хэмжээний тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 “б”, 19 дүгээр зүйл, “Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн тухай” аймгийн төрийн аудитын газрын дарга Х.Болдбаатарын мэдээллийг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 9 дүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга /Г.Пүрэвганди/-д үүрэг болгож, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нарт ЗӨВЛӨХ нь:

1.1.Бүх шатанд батлагдсан төсвийн хэрэгжилтэд зохих хууль тогтоомжийн дагуу хяналт шалгалтыг тухай бүр зохион байгуулан төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлэх

1.2.Өмч хөрөнгийн бүртгэл, хадгалалт, ашиглалт, хөдлөл өөрчлөлтөд тавих хяналтыг өндөржүүлэн үр өгөөжийг нэмэгдүүлэх

Хоёр. Аймгийн Засаг дарга /Б.Дүгэржав/-д ҮҮРЭГ БОЛГОХ нь:

2.1.Батлагдсан төсвийн хэрэгжилтийг хангах, тайлагнах төсөв захирагчид, санхүү, бүртгэлийн ажилтнуудын ажлын сахилга хариуцлагыг эрс дээшлүүлэн төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах арга хэмжээ авах.

2.2.Бүх шатанд дотоод хяналтыг үр дүнтэй зохион байгуулан тогтмолжуулах арга хэмжээ авч санхүүгийн сахилгыг бэхжүүлж, төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулж ажиллах.

2.3.Байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийн хэрэгжилт, анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлтийг эрс сайжруулан тайланг цахимаар хөтөлж гаргах ажиллагааг бүрэн нэвтрүүлэн хэвшүүлэх.

2.4.Төсөвт байгууллагуудын хэмжээнд үүссэн өр, авлагын байдалд судалгаа шинжилгээ хийж түүнийг эрх бүхий байгууллагуудын оролцоотой барагдуулах арга хэмжээг зохион байгуулах.

2.5.Төсвийн төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналтын мэдээллийг иргэд, хэрэглэгчдэд шилэн дансны хуулийн дагуу хүргэж хэрэгжилтийг хангах.

2.6.Аудитын байгууллагаас гаргасан зөвлөмж, акт, албан шаардлагын биелэлтийг хангаж, 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар хязгаарлалттай болон сөрөг, татгалзсан дүгнэлт авсан байгууллагуудын төсөв захирагчид, нягтлан бодогчдод зохих хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцож санхүүгийн сахилгыг бэхжүүлэх.

2.7.Улсын болон орон нутгийн төсөв, бусад эх үүсвэрийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийг ашиглалтад орох бүрд нягтлан бодох бүртгэлд тусган ашиглалтыг сайжруулах.

2.8.Байгууллагуудын үндсэн хөрөнгөд бүртгэлээр тавих хяналтыг дээшлүүлэн ашиглалтыг сайжруулах, хөрөнгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажиллах.

2.9.“Санхүү бүртгэлийн улсын тэргүүний ажилтнуудын зөвлөгөөн”-ийг угтаж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлан биелэлтийг хангаж, аймгийн зөвлөгөөнийг зохион байгуулах.

2.10.Санхүү, бүртгэлийн ажилтнуудыг давтан сургах, мэргэшүүлэх, цахим техник, шаардлагатай программ хангамжаар хангах ажлыг үе шаттай зохион байгуулж чадавхжуулах.

2.11.Тус тогтоолын биелэлтийг хагас, бүтэн жилээр Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулах.

Гурав. Аудитын байгууллагаас төсөв захирагчдад өгсөн зөвлөмж, албан шаардлага, актын биелэлтэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулж ажиллахыг тус аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор /Х.Болдбаатар/-т зөвлөсүгэй.

Дөрөв. Тус тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга /Б.Сандагсүрэн/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА Г.ПҮРЭВГАНДИ

ХОВД АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2019 оны 06 сарын 17 өдөр Дугаар 9/05 Ховд

Аймгийн газар зохион байгуулалтын
2019 оны төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт
оруулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4, Газрын тухай хуулийн 20.1.2 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 9 дүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 8 дугаар хуралдааны "Аймгийн газар зохион байгуулалтын 2019 оны төлөвлөгөө батлах тухай" 8/06 дугаар тогтоолын 2 дугаар заалтын "Иргэн, аж ахуйн нэгж байгууллагад үйлдвэр, үйлчилгээ эрхлэх зориулалтаар эзэмшүүлэх газрын байршил, хэмжээ, хөрөнгө оруулалт"-ын 316,966 га газрыг 59.29 га-гаар нэмэгдүүлж 376.256 га газрыг 1 дүгээр хавсралтаар, "Иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар шинээр өмчлүүлэх газрын байршил хэмжээ"-ний 67.12 га газрыг 0.3 га-гаар нэмэгдүүлж 67.42 га газрыг 2 дугаар хавсралтаар, "Иргэнд эзэмшиж байгаа хашааны газрыг үнэгүй өмчлүүлэх газрын байршил, хэмжээ"-ний 65 га газрыг 1.4 га-гаар нэмэгдүүлж 66.4 га газрыг 3 дугаар хавсралтаар, "Гэр бүлийн хэрэгцээнд болон аж ахуйн нэгж байгууллагад төмс, хүнсний ногоо, таримал мод, ургамал тариалах зориулалтаар эзэмшүүлэх газрын байршил, хэмжээ" –ний 1135.60 га газрыг 6.2 га –гаар нэмэгдүүлж 1141.8 га газрыг 4 дүгээр хавсралтаар, "Нийтийн эдэлбэрийн газрын төлөвлөлт"-ийн 205.1 га газрыг 0.28 га –гаар нэмэгдүүлж 205.38 га газрыг 5 дугаар хавсралтаар, "Сумын өвөлжөө, хаваржааны доорх газрыг эзэмшүүлэх төлөвлөлт"-ийн 174.6 га газрыг 1.6 га-гаар нэмэгдүүлж 176.2 га газрыг 6 дугаар хавсралтаар, "Иргэн аж ахуйн нэгж байгууллагад тариалангийн зориулалтаар эзэмшүүлэх газрын байршил, хэмжээ"-ний 360 га газрыг 66 га –гаар нэмэгдүүлж 426 га газрыг 7 дугаар хавсралтаар, "Суурьшлын бүсэд

шинээр үүсэх зам, шугам сүлжээний доорх газрын төлөвлөлт”-ийг 66 км-ээр нэмэгдүүлж 8 дугаар хавсралтаар, “Төсөвт байгууллагын зайлшгүй хэрэгцээнд зориулан эзэмшүүлэх газрын байршил, хэмжээ”-ний 17.53 га газрыг 614.296 га-гаар нэмэгдүүлж 631.826 га газрыг 12 дугаар хавсралтаар, ”Эрчимжсэн мал аж ахуйн зориулалтаар эзэмшүүлэх газрын байршил, хэмжээ”-ний 20 га газрыг 5 га –гаар нэмэгдүүлж 25 га газрыг 13 дугаар хавсралтаар, “Иргэнд гэр бүлийн хэрэгцээнд зориулан шинээр эзэмшүүлэх газрын байршил, хэмжээ”-ний 13.87 га газрыг 54.79 га –гаар нэмэгдүүлж 68.66 га газрыг 14 дүгээр хавсралтаар, “Түгээмэл тархацтай ашигт малтмалын зориулалтаар үйл ажиллагаа явуулах иргэн аж ахуйн нэгж байгууллагад эзэмшүүлж ашиглуулах газрын төлөвлөлт”-ийн 50 га газрыг 60 га-гаар нэмэгдүүлж 110 га газрыг 16 дугаар хавсралтаар, “Хүний үйл ажиллагааны улмаас элэгдэл, эвдрэлд орж ашиглалтгүй орхигдсон газрыг өөрийн хүч хөрөнгөөр нөхөн сэргээсэн иргэн аж ахуйн нэгж байгууллагад үйлдвэрлэлийн зориулалтаар давуу эрхээр эзэмшүүлэх газрын байршил, хэмжээ”-ний 5.6 га газрыг 20 га-гаар нэмэгдүүлж 25.6 га газрыг 19 дүгээр хавсралтаар тус тус нэмэгдүүлж өөрчлөн баталсугай.

2.Тус тогтоолын 10 дугаар хавсралтаар баталсан “Тухайн жилд тусгай хамгаалалтад авах газар нутгийн байршил, хэмжээ”-ний төлөвлөлтийг бүхлээр нь шинэчлэн, нийт 314678,3 га газар болгон өөрчлөн баталсугай.

3.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 8 дугаар хуралдааны “Аймгийн газар зохион байгуулалтын 2019 оны төлөвлөгөө батлах тухай” 8/06 дугаар тогтоолын 2 дугаар заалтад “Ашигт малтмал олборлох зориулалтаар үйл ажиллагаа явуулах иргэн, аж ахуйн нэгж байгууллагад эзэмшүүлэх газрын төлөвлөгөө”-ний 217 га газрыг 24 дүгээр хавсралтаар, “Дуудлага худалдаагаар худалдан авсан газрыг дүйцүүлэн эзэмшүүлэх газрын төлөвлөлт”-ийн 0,06 га газрыг 25 дугаар хавсралтаар тус тус нэмэлт оруулж баталсугай.

4.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2018 оны 08 дугаар хуралдааны “Аймгийн газар зохион байгуулалтын 2019 оны төлөвлөгөө батлах тухай” 8/06 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 13 дугаар заалтын Жаргалант сумын Цамбагарав баг Эсба-гийн урд 0,06 га газрыг сүүний үйлдвэрлэл, худалдааны зориулалтаар, дуудлага худалдааны анхны үнээр гэж заасныг хүчингүй болгосугай.

5.Аймгийн Засаг дарга /Б.Дүгэржав/-д ДААЛГАХ нь:

5.1.Аймгийн 2019 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлтөөр оруулсан газрыг кадастрын зургаар баталгаажуулан, нийтэд

сурталчилж, хэрэгжилтийг хангах удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах

6. Сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга нарт зөвлөн, Засаг дарга нарт ДААЛГАХ нь:

6.1 Аймгийн газар зохион байгуулалтын 2019 оны төлөвлөгөөнд орсон нэмэлт, өөрчлөлтийн хэрэгжилтийг ханган ажиллах

ХУРЛЫН ДАРГА Г.ПҮРЭВГАНДИ